



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|-----|---|-----|
| 74. | Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай | 359 |
| 75. | Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 379 |
| 76. | Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 380 |
| 77. | Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 381 |
| 78. | Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 381 |
| 79. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 382 |
| 80. | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 383 |
| 81. | Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 383 |
| 82. | Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 384 |
| 83. | Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 385 |
| 84. | Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 386 |
| 85. | Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 387 |



| | | | |
|--|---|------------|-----|
| 86. | Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 388 |
| 87. | Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 389 |
| МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ | | | |
| 88. | Зарим хууль, тогтоолын төсөл буцаах тухай | Дугаар 01 | 389 |
| 89. | Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 06 | 396 |
| 90. | Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай | Дугаар 09 | 397 |
| 91. | Төрийн албаны зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай | Дугаар 10 | 397 |
| 92. | Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай | Дугаар 11 | 398 |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ | | | |
| 93. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 10 | 398 |
| 94. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 11 | 399 |
| МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ | | | |
| 95. | Дүрэм батлах тухай | Дугаар 151 | 399 |

| | | | |
|-----|--|------------|-----|
| 96. | Протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнийг тогтоох тухай | Дугаар 153 | 418 |
| 97. | Аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | Дугаар 158 | 423 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Төв банк /Монголбанк/-ны тухай³, Банкны тухай⁴, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³Төв банк /Монголбанк/-ны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

⁴Банкны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁵Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1996 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“Хадгаламжийн даатгалын корпорацн” гэж энэ хуульд заасан банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг;

3.1.2.“хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа” гэж энэ хуульд заасны дагуу банкнаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөхтэй холбогдсон үйл ажиллагааг;

3.1.3.“банк” гэж Банкны тухай хуулийн 3.1.1-д заасан хуулийн этгээдийг болон мөн хуульд заасны дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авч, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбарыг;

3.1.4.“хадгаламж” гэж Банкны тухай хуульд заасан харилцах болон мөнгөн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг;

3.1.5.“хадгаламжийн даатгалын сан” гэж энэ хуулийн 10.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн, энэ хуулийн 11.1-д заасан зориулалтаар зарцуулах хөрөнгийг;

3.1.6.“даатгалын тохиолдол” гэж Банкны тухай хуулийн 57.3-т заасны дагуу Монголбанк банкныг албадан татан буулгах шийдвэр гаргасныг;

3.1.7.“хамтарсан данс” гэж банкин дахь дангаар, эсхүл хамтран захиран зарцуулах эрхтэй хоёр буюу түүнээс дээш этгээдийн эзэмшлийн нэг дансыг.

4 дүгээр зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын зарчим

4.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгал /цаашид “хадгаламжийн даатгал” гэх/-ын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:



4.1.1.санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах;

4.1.2.энэ хуулийн 8.1-д заасан даатгалын нөхөн төлбөрийг төлөхдөө тухайн банкны хадгаламж эзэмшигч бүрийг хамруулах;

4.1.3.Банкны тухай хуулийн 6.1.1, 6.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламжийн даатгалд хамрагдах;

4.1.4.ил тод, хариуцлагатай байх.

5 дугаар зүйл.Хадгаламжийн даатгал

5.1.Банкны тухай хуулийн 6.1.1, 6.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламж эзэмшигчийн хадгаламжийг энэ хуульд заасны дагуу хадгаламжийн даатгалд заавал даатгуулж, даатгалын хураамж төлнө.

5.2.Монголбанк банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай бүр энэ тухай Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэнэ.

5.3.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 5.1-д заасны дагуу хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд оролцож байгааг нотолсон гэрчилгээг тухайн банкинд олгоно.

5.4.Дараах тохиолдолд хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд банкны оролцох оролцоо дуусгавар болно:

5.4.1.татан буулгаж байгаа банкны хадгаламж эзэмшигчдийн даатгалын нөхөн төлбөрийг олгож дууссан;

5.4.2.банкийг улсын бүртгэлээс хассан.

6 дугаар зүйл.Даатгалын тохиолдол

6.1.Банкны тухай хуулийн 57.3-т заасны дагуу Монголбанк банкныг албадан татан буулгах шийдвэр гаргасан өдрийг даатгалын тохиолдол бий болсон өдөрт тооцно.

6.2.Монголбанк банкныг албадан татан буулгах шийдвэр гаргамагц энэ тухай Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэх үүрэгтэй.



6.3.Даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид энэ хуульд заасны дагуу Хадгаламжийн даатгалын корпорациас даатгалын нөхөн төлбөр шаардах эрх үүснэ.

7 дугаар зүйл. Даатгалд үл хамаарах нөхцөл

7.1. Дараах хадгаламж хадгаламжийн даатгалд хамаарахгүй:

7.1.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн⁶ 4.1-д заасан этгээдийн нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр нээсэн данс;

7.1.2. нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл;

7.1.3. нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй хадгаламж.

7.2. Дараах этгээдийн хадгаламж хадгаламжийн даатгалд хамаарахгүй:

7.2.1. банк;

7.2.2. төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага;

7.2.3. эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан;

7.2.4. Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд;

7.2.5. даатгалын тохиолдол бий болохоос өмнөх гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага;

7.2.6. Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон дор дурдсан хадгаламж эзэмшигч:

7.2.6.а. гүйлгээний төрөл, эрсдэлийн түвшин, зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцааны төрөл зэргийг харгалзан үзэхэд бусад хадгаламж эзэмшигчээс онцгой нөхцөлтэй зээл авсан;

⁶Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



7.2.6.б.банкны бусад хадгаламж эзэмшигчээс илт бага хүүтэй зээл авсан;

7.2.6.в.даатгалын тохиолдол бий болох үед Монголбанкны статистик мэдээллээр хадгаламж эзэмшигчдийн авч байгаа хадгаламжийн дундаж хүүгээс 50 хувиас илүү хүү авсан.

7.3.Даатгалын тохиолдол бий болоход энэ хуулийн 7.2-т заасан этгээдэд даатгалын нөхөн төлбөр төлөхгүй.

7.4.Даатгалын тохиолдол бий болоход Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн⁷ 134.9-д заасны дагуу битүүмжилсэн болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг нь түдгэлзүүлсэн дансны хадгаламж эзэмшигчид зөвхөн битүүмжлэх болон гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болсон тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

8 дугаар зүйл.Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

8.1.Даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчийн тухайн банкин дахь төгрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлнө.

9 дүгээр зүйл.Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох

9.1.Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо хадгаламж эзэмшигч бүрийн тухайн банкинд эзэмшиж байгаа нийт хадгаламжийн дүн болон гэрээний дагуу хуримтлагдсан хүүгийн дүнг даатгалын тохиолдол бий болсон өдрийн байдлаар нэгтгэж, хадгаламж эзэмшигчээс тухайн банкинд төлбөл зохих зээл, хүүгийн хамт хасч тодорхойлно.

9.2.Хадгаламж эзэмшигч даатгалын тохиолдол бий болсон банкинд хэд хэдэн хадгаламжийн данстай бол түүний бүх дансыг нэг дансанд нэгтгэн даатгалын нөхөн төлбөрийг тооцно.

9.3.Хамтарсан данс эзэмшигчдэд төлөх даатгалын нөхөн төлбөрийн нийт хэмжээ энэ хуулийн 8.1-д заасан хэмжээнээс илүүгүй байна.

9.4.Хамтарсан дансан дахь эзэмшлийн хувь нь тэнцүү биш гэдгийг нотолсон баримт гаргаснаас бусад тохиолдолд хамтарсан данс эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөрийг тэнцүү хувааж тооцно.

⁷Эрүүгийн байцаан шийтгэх хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**10 дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын сан,
түүний эх үүсвэр**

10.1.Хадгаламжийн даатгалын сан /цаашид “Сан” гэх/-гийн удирдлагыг Хадгаламжийн даатгалын корпорацн хэрэгжүүлнэ.

10.2.Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

10.2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн⁸ 2.5-д заасны дагуу тухайн банкнаас Засгийн газрын Монголбанкн дахь тусгай дансанд төвлөрүүлсэн шимтгэл;

10.2.2.улсын төсвөөс Санд оруулсан эхлэлтийн хөрөнгө;

10.2.3.Монголбанкнаас Санд оруулсан эхлэлтийн хөрөнгө;

10.2.4.хадгаламжийн даатгалын хураамж;

10.2.5.Сангийн хөрөнгө оруулалтаас олсон орлого;

10.2.6.даатгалын тохиолдол бий болсон банкны актив хөрөнгийг борлуулсны орлого;

10.2.7.Засгийн газар, Монголбанк, олон улсын байгууллагаас олгосон зээл, тусламж, бусад санхүүжилт;

10.2.8.гадаадын банк болон олон улсын санхүүгийн байгууллагаас Хадгаламжийн даатгалын корпорацийн авсан зээл;

10.2.9.Хадгаламжийн даатгалын корпорацийн гаргасан бондын эх үүсвэр;

10.2.10.хуульд заасан бусад эх үүсвэр.

11 дүгээр зүйл.Сангийн актив хөрөнгийн зарцуулалт

11.1.Сангийн актив хөрөнгийг дор дурдсанаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно:

11.1.1.хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөх;

⁸Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 44 дугаарт нийтлэгдсэн.



11.1.2.төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкны хадгаламжийг шилжүүлэн авсан банкинд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

11.1.3.Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

11.1.4.Хадгаламжийн даатгалын корпорацийн авсан зээл болон гаргасан бондын үндсэн өр, хүүгийн төлбөр төлөх.

11.2.Энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэгийг уг дэмжлэгийн хэмжээ нь төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкны хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөхөд шаардагдах хөрөнгөөс бага байх тохиолдолд үзүүлнэ.

11.3.Энэ хуулийн 11.1.2-т заасан санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх журмыг энэ хуулийн 22.1-д заасан Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

12 дугаар зүйл. Сангийн хөрөнгө оруулалт

12.1.Хадгаламжийн даатгалын корпораци Сангийн актив хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай, ашигтай байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд байршуулж болно:

12.1.1.Засгийн газраас гаргасан болон батлан даасан үнэт цаас;

12.1.2.Монголбанкны үнэт цаас;

12.1.3.зээлжих зэрэглэл тогтоодог нэр хүнд бүхий олон улсын байгууллагаас AAA-аас доошгүй үнэлгээ авсан гадаад улсын Засгийн газрын болон олон улсын санхүүгийн байгууллагын үнэт цаас;

12.1.4.олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкинд нээсэн хадгаламж.

12.2.Хадгаламжийн даатгалын корпорацийн хөрөнгө оруулалтын журам, заавар болон хөрөнгө оруулалтын бодлогыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.



**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖ,
НӨХӨН ТӨЛБӨР**

**13 дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын хураамж,
түүнийг төлөх**

13.1.Банк хадгаламжийн даатгалын хураамж /цаашид “хураамж” гэх/-ийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооноос баталсан хадгаламжийн даатгалын хураамжийн журмын дагуу Хадгаламжийн даатгалын корпорацид төлнө.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан хураамж нь дор дурдсан хураамжаас бүрдэнэ:

- 13.2.1.эхлэлтийн хураамж;
- 13.2.2.улирлын хураамж;
- 13.2.3.онцгой хураамж.

13.3.Эхлэлтийн хураамж нь тухайн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний нэг хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

13.4.Банк эхлэлтийн хураамжийг Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

13.5.Улирлын хураамж нь өмнөх улирлын сар бүрийн эцсийн өдрийн энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хадгаламжийн дундаж дүнг энэ хуулийн 14.1-д заасны дагуу тооцсон улирлын хураамжийн хувиар үржүүлсэн дүнтэй тэнцүү хэмжээтэй байна.

13.6.Улирлын хураамжийг төлөх хугацааг Хадгаламжийн даатгалын корпорацийн нэхэмжлэлд заана.

13.7.Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор дараа жилийн улирлын хураамжийн хувийг 0.125 хувиас хэтрүүлэхгүй хэмжээгээр тогтооно.

13.8.Сангийн хөрөнгө гишүүн банкуудын энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хадгаламжийн дүнгийн 10 хувьд хүрвэл Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо улирлын хураамжийг тооцох болон хуримтлуулахыг түр зогсоож болно.

13.9.Даатгалын нөхөн төлбөрийг төлөхөд Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд онцгой хураамжийг төлөх шийдвэрийг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо гаргаж болно.

13.10.Онцгой хураамжийн хувийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хадгаламжаас тооцох бөгөөд уг хувь нь жилийн 0.5 хувиас хэтрэхгүй байна.

13.11.Онцгой хураамжийг өмнөх улирлын сар бүрийн эцсийн өдрийн энэ хуулийн 7.1-д зааснаас бусад хадгаламжийн дундаж дүнг онцгой хураамжийн хувиар үржүүлэн тооцно.

13.12.Хэрэв банк хүсэлт гаргавал энэ хуулийн 13.6-д заасан хугацааг Хадгаламжийн даатгалын корпораци ажлын таван өдрөөр сунгаж болно.

13.13.Энэ хуулийн 13.12-т заасан хугацаанд банк хураамжийн төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпораци Монголбанкинд энэ тухай мэдэгдэж, тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас төлбөл зохих хураамжийн дүнгээр суутган төлүүлэх хүсэлтийг Монголбанкинд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

13.14.Монголбанкнаас албадан татан буулгасан банкны даатгалын хураамж төлөх үүрэг нь даатгалын тохиолдол бий болсон улирлын эцсийн өдрөөр дуусгавар болно.

13.15.Энэ хуулийн 13.1-д заасны дагуу банкнаас төлсөн хураамжийг буцааж олгохгүй.

14 дүгээр зүйл.Улирлын хураамжийн хувь

14.1.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 13.2.2-т заасан улирлын хураамжийн хувийг тухайн банкны эрсдэлийн түвшингээс хамааруулан тогтоосон аргачлалын дагуу тооцно.

14.2.Хадгаламжийн даатгалын корпораци банкны эрсдэлийн түвшинг үнэлэхдээ Монголбанкны мэдээлэлд үндэслэнэ.

14.3.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 14.2-т заасан мэдээллийн нууцлалыг хадгална.

14.4.Энэ хуулийн 14.1-д заасан аргачлалыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны санал болгосноор Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.



15 дугаар зүйл.Хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгох

15.1.Монголбанкнаас даатгалын тохиолдол бий болсон тухай мэдэгдлийг Хадгаламжийн даатгалын корпорацид ирүүлснээс хойш ажлын гурван өдөрт багтаан Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гаргана.

15.2.Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын нөхөн төлбөр олгох хэлбэр, хугацааны талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр энэ хуулийн 15.1-д заасан шийдвэр гарснаас хойш 48 цагийн дотор мэдээлж, мэдээллийн хувийг Монголбанкинд хүргүүлнэ.

15.3.Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо энэ хуулийн 15.1-д заасан шийдвэрийг гаргаснаас хойш Хадгаламжийн даатгалын корпораци ажлын 30 өдрийн дотор энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан банкаар дамжуулан даатгалын нөхөн төлбөр олгож эхэлнэ.

15.4.Гадаад валютын хадгаламжийн даатгалын нөхөн төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэх бөгөөд түүний дүнг даатгалын тохиолдол бий болсон өдрийн Монголбанкнаас зарласан ханшаар тооцно.

15.5.Даатгалын нөхөн төлбөр олгох журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

15.6.Хадгаламжийн даатгалын корпораци даатгалын нөхөн төлбөр олголтын явцын талаар хадгаламж эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан мэдээллийн агуулга, түүнийг түгээх журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

16 дугаар зүйл.Даатгалын нөхөн төлбөр олгох банк

16.1.Даатгалын нөхөн төлбөрийг банкаар дамжуулан олгоно.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан даатгалын нөхөн төлбөр олгох банкыг даатгалын тохиолдол бий болсон тухай бүр Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо Монголбанктай зөвшилцөн сонгон шалгаруулна.

16.3.Даатгалын нөхөн төлбөр олгох банкинд тавих шаардлага, сонгон шалгаруулах журмыг Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо батална.

16.4.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 16.1-д заасан банктай гэрээ байгуулна.

17 дугаар зүйл.Хадгаламж эзэмшигчийн эрх

17.1.Хадгаламж эзэмшигч даатгалын тохиолдол бий болоход даатгалын нөхөн төлбөр авах эрхтэй.

17.2.Хадгаламжийн гэрээг гуравдагч этгээдийг төлөөлөн байгуулсан бол даатгалын нөхөн төлбөр авах эрхийг уг гуравдагч этгээд эдэлнэ.

17.3.Өв залгамжлалаар даатгалын нөхөн төлбөр авахад өв залгамжлагчийн өөрийн нэр дээр хадгалуулсан хадгаламжид авах даатгалын нөхөн төлбөр хамаарахгүй.

18 дугаар зүйл.Шаардах эрх

18.1.Хадгаламжийн даатгалын корпорациас хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгосон хэмжээгээр хадгаламж эзэмшигчийн шаардах эрх Хадгаламжийн даатгалын корпорацид шилжинэ.

18.2.Хадгаламжийн даатгалын корпораци энэ хуулийн 8.1-д заасны дагуу олгосон даатгалын нөхөн төлбөрийг татан буугдсан банкны хөрөнгөөс Банкны тухай болон Дампуурлын тухай хуулийн⁹ дагуу нэхэмжилнэ.

18.3.Хадгаламж эзэмшигчийн Хадгаламжийн даатгалын корпорациас шаардах эрх энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан хадгаламж болон хадгаламж эзэмшигч, 8 дугаар зүйлд заасан нөхөн төлөх хэмжээнээс илүү гарсан хадгаламжид хамаарахгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

19 дүгээр зүйл.Хадгаламжийн даатгалын корпорацийн эрх зүйн байдал

19.1.Хадгаламжийн даатгалын корпораци /цаашид “Корпораци” гэх/ нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд байна.

⁹Дампуурлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



19.2.Корпорацийн төв Монгол Улсын нийслэлд байрлана.

19.3.Корпораци дүрэмтэй байх бөгөөд Корпорацийн дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

19.4.Корпораци тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

19.5.Корпораци Монголбанкинд төгрөгийн болон валютын харилцах, хадгаламжийн данстай байна.

19.6.Корпораци өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор банкинд харилцах данс нээж болно.

19.7.Корпораци дотоод хяналтын албатай байх бөгөөд дотоод хяналтын алба Хадгаламжийн даатгалын Үндэсний хороонд ажлаа тайлагнана.

19.8.Корпораци үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд¹⁰ заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл.Корпорацийн үйл ажиллагаа

20.1.Корпораци дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

20.1.1.даатгалын хураамжийг төвлөрүүлэх;

20.1.2.даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөх;

20.1.3.Сангийн хөрөнгийг энэ хуульд заасны дагуу удирдах;

20.1.4.Сангийн санхүүгийн эрсдэлийг үнэлэх зорилгоор банкны эрсдэлийг үнэлж, хянах.

20.2.Корпораци нь энэ хуульд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй бөгөөд ашгийн төлөө хуулийн этгээд байгуулахыг хориглоно.

21 дүгээр зүйл.Корпорацийн бүрэн эрх

21.1.Корпораци дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

¹⁰Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



21.1.1.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хадгаламж болон хадгаламж эзэмшигчдийн талаарх сар, улирлын тайлан, бусад мэдээллийг банкнаас авах;

21.1.2.банкны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, санхүүгийн үзүүлэлт, бусад мэдээллийг банкнаас авах;

21.1.3.хадгаламжийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой, эсхүл даатгалын тохиолдлын магадлалыг үнэлэхэд шаардлагатай гэж үзвэл банкинд хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Монголбанкинд тавих;

21.1.4.татан буугдсан банкны эрх хүлээн авах ажиллагаанд Корпорацийн төлөөллийг оролцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, гүйцэтгүүлэх;

21.1.5.Корпорацийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй байгаа тохиолдолд Монголбанк, Засгийн газраас зээл, санхүүгийн дэмжлэг авах;

21.1.6.Корпораци өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар журам баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих.

22 дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо

22.1.Корпорацийн удирдах дээд байгууллага нь Хадгаламжийн даатгалын Үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэх/ байна.

22.2.Үндэсний хороо долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Үндэсний хорооны гишүүн дараах этгээд байна:

22.2.1.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга;

22.2.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

22.2.3.Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;

22.2.4.Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголын банкны холбооны ерөнхийлөгч тус тус нэр дэвшүүлж, Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар томилсон гурван гишүүн;



22.2.5.Корпорацийн гүйцэтгэх захирал.

22.3.Энэ хуулийн 22.2.4-т заасан Үндэсний хорооны гурван гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар томилох бөгөөд тэдгээрийг нэг удаа улируулан томилж болно.

22.4.Энэ хуулийн 22.2.4-т заасан гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

22.4.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

22.4.2.ял шийтгэлгүй;

22.4.3.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь Корпорацийг удирдахад харшлахгүй байх;

22.4.4.банк, санхүү, даатгал, эрх зүй, эдийн засгийн аль нэг чиглэлээр мэргэшсэн;

22.4.5.банк, санхүү, даатгалын салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаал хашсан;

22.4.6.төрийн улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал хашдаггүй байх;

22.4.7.банк, санхүүгийн байгууллагад ажилладаггүй байх;

22.4.8.банк, санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч болон бусад холбогдох этгээд бус байх;

22.4.9.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс шалтгаалаагүй нь нотлогдсон байх.

22.5.Үндэсний хорооны дарга болон Корпорацийн гүйцэтгэх захирлаас бусад гишүүний урамшууллын хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.6.Үндэсний хорооны ажиллах журам, Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн гүйцэтгэх захирал болон Корпорацийн ажилтны ёс зүйн дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.



22.7. Дараах тохиолдолд Үндэсний хорооны гишүүнийг энэ хуулийн 22.3-т заасан хугацаанаас өмнө Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтарсан шийдвэрээр үүрэгт ажлаас чөлөөлнө:

22.7.1. үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

22.7.2. тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

22.7.3. өвчний улмаас цаашид үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан;

22.7.4. үүрэгт ажлаа хоёр ба түүнээс дээш удаа хангалтгүй биелүүлсэн;

22.7.5. энэ хуулийн 22.4-т заасан шаардлагыг хангахгүй болсон;

22.7.6. ёс зүйн зөрчил гаргасан;

22.7.7. гэмт хэрэг үйлдсэн талаар шүүхийн эцсийн шийдвэр гарсан.

22.8. Үндэсний хорооны гишүүнийг энэ хуулийн 22.2.4, 22.3, 22.7-д заасны дагуу томилох, чөлөөлөхдөө залгамж чанарыг хадгалах зарчмыг баримтална.

22.9. Үндэсний хорооны гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд банкинд ажиллахыг хориглоно.

22.10. Үндэсний хорооны гишүүн үйл ажиллагаандаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг¹¹ мөрдөнө.

23 дугаар зүйл. Үндэсний хорооны хуралдаан

23.1. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

23.2. Үндэсний хорооны дарга нь хуралдаан даргалагч байна.

23.3. Үндэсний хорооны даргын түр эзгүйд түүний үүргийг Үндэсний хорооны даргын томилсон аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд Үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэж байгаа гишүүн Үндэсний хорооны даргаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ.

¹¹Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийлэгдсэн.



23.4. Үндэсний хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

23.5. Үндэсний хорооны хоёроос доошгүй гишүүн, эсхүл Корпорацийн гүйцэтгэх захирлын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн Үндэсний хорооны дарга ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

23.6. Үндэсний хорооны хуралдаан гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

23.7. Үндэсний хорооны хуралдаанд Корпорацийн ажилтан, мэргэжлийн хүмүүсийг урилгаар оролцуулж болно.

23.8. Үндэсний хорооны хуралдааны явцад тэмдэглэл хөтөлж, түүнд хуралдаанд оролцсон бүх гишүүн гарын үсэг зурж, баталгаажуулна.

23.9. Үндэсний хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах ба уг шийдвэрт хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

23.10. Үндэсний хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

23.11. Үндэсний хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

23.12. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаар ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй гэж Үндэсний хорооны дарга, гишүүн үзсэн бол энэ тухай хуралдаан эхлэхээс өмнө мэдэгдэх бөгөөд тухайн асуудлыг хэлэлцэх болон санал хураахад уг гишүүн оролцохгүй.

24 дүгээр зүйл. Үндэсний хорооны бүрэн эрх

24.1. Үндэсний хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. Корпорацийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах;

24.1.2. Бүрэн эрхийнхээ хүрээнд журам, заавар баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

24.1.3. Корпорацийн стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;



24.1.4.Корпорацийн бүтэц, үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, Корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих;

24.1.5.Корпорацийн гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулж томилох, түүнтэй гэрээ байгуулах, чөлөөлөх;

24.1.6.хадгаламж эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөр төлөх тухай шийдвэр гаргах;

24.1.7.хадгаламжийн даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтоох;

24.1.8.аудитын байгууллагыг сонгох;

24.1.9.Корпорацийн санхүүгийн тайланг зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргах;

24.1.10.Корпорацийн дотоодхяналтын албанышалгалтын дүнг хэлэлцэж, шийдвэр гаргах;

24.1.11.Корпорацийн үйл ажиллагааны үр дүнгийн тайланг хагас жил тутамд Монголбанкны Ерөнхийлөгч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх;

24.1.12.энэ хууль болон Корпорацийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

25 дугаар зүйл.Корпорацийн гүйцэтгэх захирал

25.1.Корпорацийн гүйцэтгэх захирал нь Корпорацийн дүрэм болон Үндэсний хороотой байгуулсан гэрээнд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Үндэсний хорооноос баталсан стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Корпорацийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

25.2.Үндэсний хороо Корпорацийн гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулж, дөрвөн жилийн хугацаатай томилно.

25.3.Корпорацийн гүйцэтгэх захирал нь энэ хуулийн 22.4-т заасан шаардлагыг хангасан байна.



25.4.Корпорацийн гүйцэтгэх захирлын эрх, үүргийг Корпорацийн дүрмээр тогтооно.

25.5.Корпорацийн гүйцэтгэх захирлыг энэ хуулийн 22.7-д заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

25.6.Энэ хуулийн 22.7.1-д заасан үндэслэлээр Корпорацийн гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тохиолдолд түүний бүрэн эрхийн хугацаа дараагийн гүйцэтгэх захирлыг томилсноор дуусгавар болно.

25.7.Ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчтэй байх зэрэг тохиолдолд Корпорацийн гүйцэтгэх захирал Үндэсний хорооны зөвшөөрсөн этгээдэд бүрэн эрхээ шилжүүлж болох бөгөөд ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

25.8.Корпорацийн гүйцэтгэх захирал үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд банкинд ажиллахыг хориглоно.

26 дугаар зүйл.Дотоод мэдээллийн нууцыг хадгалах

26.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн ажилтан болон Корпорацид гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа этгээд албан үүргийнхээ дагуу олж мэдсэн, Корпораци, банкны талаарх мэдээ, мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

26.2.Үндэсний хорооны гишүүн, Корпорацийн ажилтан болон Корпорацид гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа этгээдийн энэ хуулийн 26.1-д заасны дагуу хүлээсэн үүрэг тэдгээрийн Корпорацитай холбогдсон үүрэгт ажил нь дуусгавар болсноос хойш хүчин төгөлдөр байна.

27 дугаар зүйл.Санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайлан

27.1.Корпорацийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд¹² заасны дагуу гаргаж, санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланд аудит хийлгэнэ.

27.2.Корпорацийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.2-т заасан бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

¹²Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 4 дугаарт нийтлэгдсэн.



27.3.Корпорацийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хоёр жилд нэгээс доошгүй удаа Үндэсний хорооноос сонгосон, олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

27.4.Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Корпорацийн гүйцэтгэх захирал хариуцна.

27.5.Корпораци энэ хуулийн 27.1-д заасан тухайн жилийн тайлан, аудитын дүгнэлтийг дараа жилийн 3 дугаар сарын 01-ний дотор Үндэсний хороогоор хэлэлцүүлж, тайланг батлуулна.

27.6.Энэ хуулийн 27.1-д заасан тухайн жилийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний дотор Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнана.

27.7.Корпораци жилийн тайлан, тайлан тэнцэл, орлого зарлагын тайлан болон аудитын дүгнэлтийг нийтэд мэдээлнэ.

28 дугаар зүйл.Корпорациас төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцах

28.1.Корпорациас төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцах харилцааг Корпорацийн дүрмээр зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

29 дүгээр зүйл.Тайлан, мэдээ, мэдээллээр хангах талаарх банкны үүрэг

29.1.Корпорацийг энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг банк тогтоосон хэлбэрээр, хугацаанд нь Корпорацид хүргүүлнэ.

29.2.Корпорацийн хүсэлтээр банк Корпорацийг хуулийн дагуу үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

29.3.Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журмыг Үндэсний хороо батална.



29.4.Корпорацид ирүүлсэн санхүүгийн тайлан, мэдээ, мэдээллийн үнэн зөвийг банк хариуцна.

29.5.Банк хадгаламжийн даатгалын тогтолцоо, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээний талаарх мэдээллээр Үндэсний хорооноос баталсан журмын дагуу хадгаламж эзэмшигчийг хангах үүрэгтэй.

29.6.Энэ хуулийн 29.5-д заасан мэдээллийг банк зар сурталчилгааны зорилгоор болон банкны салбарын тогтвортой байдал, хадгаламж эзэмшигчдийн итгэлд сөргөөр нөлөөлөх байдлаар ашиглахыг хориглоно.

30 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

30.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

30.1.1.энэ хуулийн 7.3-т заасныг зөрчиж, даатгалын нөхөн төлбөр төлсөн бол зориудаар худал мэдээлэл өгсөн болон уг мэдээллийг ашиглан даатгалын нөхөн төлбөр олгосон ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

30.1.2.энэ хуулийн 8.1-д заасны дагуу даатгалын нөхөн төлбөр олгоогүй ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 9.1-9.3-т заасны дагуу олгох даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг зориудаар буруу тооцсон буюу худал мэдээлэл өгсөн ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

30.1.3.энэ хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас бусад хэлбэрээр Сангийн хөрөнгийг зарцуулсан, энэ хуулийн 12 дугаар зүйлд зааснаас бусад хэлбэрээр хөрөнгө оруулалт хийсэн, энэ хуулийн 20.2-т заасныг зөрчиж, ашгийн төлөө хуулийн этгээд байгуулсан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөн зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

30.1.4.энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчиж дотоод мэдээллийн нууцыг задруулсан ажилтан, албан тушаалтныг нэг



сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

30.2.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн банкинд Монголбанкны улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

30.2.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу даатгалын хураамж төлөөгүй, эсхүл төлбөл зохих хугацаанд төлөөгүй бол гүйцэтгээгүй дүнгээс Монголбанкны бодлогын хүү дээр 5 хувийг нэмсэнтэй тэнцэх хэмжээтэй хувиар торгох, уг зөрчлийг давтан гаргасан тохиолдолд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

30.2.2.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд удаа дараа ирүүлээгүй, дутуу, эсхүл буруу мэдээ, мэдээллийг удаа дараа ирүүлсэн бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох;

30.2.3.хадгаламж эзэмшигчид энэ хуулийн 29.5-д заасны дагуу мэдээлэл хүргээгүй, эсхүл хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар буруу мэдээлэл хүргэсэн, энэ хуулийн 29.6-д заасныг зөрчсөн бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

31 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

31.1.Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:



1/19² дугаар зүйл:

“19² дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих

1.Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавина.”

2/23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

“5/санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хадгаламжийн даатгалын корпорацид санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

2 дугаар зүйл.Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “банкнаас” гэснийг “банк, Хадгаламжийн даатгалын корпорациас” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 64 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 64.1.4 дэх заалт нэмсүгэй:

“64.1.4.хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр;”

2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 64.1.4-64.1.7 дахь заалтын дугаарыг “64.1.5-64.1.8” гэж өөрчилсүгэй.



3 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 32 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 32.5.4 дэх заалт нэмсүгэй:

“32.5.4.хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр;”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.5.4-32.5.6 дахь заалтын дугаарыг “32.5.5-32.5.7” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.4 дэх хэсэг нэмсүгэй:

“3.4.Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалтай холбогдсон харилцааг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулиар зохицуулна.”



2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “3.1-3.3-т” гэснийг “3.1-3.4-т” гэж, 3.4 дэх хэсгийн дугаарыг “3.5” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 18.1.10 дахь заалт нэмсүгэй:

“18.1.10.хадгаламжийн даатгалын сангийн хураамжийн орлого.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн “улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш гурван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого” гэсэн 18.1.8 дахь заалтын дугаарыг “18.1.9” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “банкны тухай хуульд заасан Хөгжлийн банкны” гэснийг “банк, Хадгаламжийн даатгалын корпорацийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ТУХАЙ БАГЦ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль /цаашид “Шүүхийн тухай багц хууль” гэх/-ийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдийн орон тоог нэмж, нэмэгдсэн орон тоонд шүүгчийг сонгон шалгаруулан, Монгол Улсын Их Хуралд танилцуулж, Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх ажлыг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдөр баталсан Шүүхийн тухай хуульд нийцүүлэн зохион байгуулна.

2 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Засгийн газар Шүүхийн тухай багц хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дүрэм, стандарт, журмыг боловсруулж, батлуулах, бүтэц, зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, санхүү, эдийн засгийн холбогдох арга хэмжээг 2013 оны 4 дүгээр сарын 15-наас мөн оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 17.3.6 дахь заалт:

“17.3.6.энэ хуулийн 7.4, 17.3.4-т заасан болон бусад хуульд заасан асуудлыг хуралдаанаар шийдвэрлэх;”

2/25 дугаар зүйлийн 25.2.8 дахь заалт:

“25.2.8.хэрэг хуваарилах журмыг батлах;”

2 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

3 дугаар зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн, танхимын тэргүүнийг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн тус тус өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч гурван жилийн хугацаагаар томилж, тухайн шүүхэд нэг удаа улируулан томилж болно.”

4 дүгээр зүйл.2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “төлөөлөгчдийг” гэснийг “төлөөлөгчийг” гэж, “төлөөлөгчдийн” гэснийг “төлөөлөгчийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “10.2-т” гэснийг “9.2-т” гэж, 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь заалтын “шүүхийн танхимыг энэ хуулийн 19.3-т заасны дагуу” гэснийг “энэ хуулийн 15.2-т заасан танхимыг” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтын “анхан шатны” гэснийг “давж заалдах” гэж, 33 дугаар зүйлийн 33.1



дэх хэсгийн “2013 оны 7 дугаар сарын 01-ний” гэснийг “2013 оны 4 дүгээр сарын 15-ны” гэж, 17 дугаар зүйлийн 17.3.6 дахь заалтын дугаарыг “17.3.7” гэж, 25 дугаар зүйлийн 25.2.8 дахь заалтын дугаарыг “25.2.9” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн захиргааны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“5.2.Ерөнхий зөвлөл нь анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд ажлаа тайлагнана.”

2/13 дугаар зүйлийн 13.4-13.6 дахь хэсэг:

“13.4.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүдийг нэг удаа улируулан томилж болно.

13.5.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс авч, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

13.6.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдсөн тохиолдолд түүний цалин хөлсийг бууруулахгүйгээр мэргэжлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжүүлж болно.”

3/19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт:

“19.1.4.Ерөнхий зөвлөлийн гишүүнд санал болгосон шүүгчдийн хамтарсан зөвлөгөөн болон Хуульчдын холбоо, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эгүүлэн татах шийдвэр гаргасан.”



2 дугаар зүйл.Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.3.Ёс зүйн хорооны гишүүнд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос гурав, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гурван хүний нэрийг дэвшүүлнэ. Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно.”

3 дугаар зүйл.Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “танхим” гэснийг “холбоо” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “таван” гэснийг “гурван” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “2014 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2013 оны 4 дүгээр сарын 15-ны” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн дугаарыг “13.7” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “шүүгч,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21.6 дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 35.2 дахь хэсэг нэмсүгэй:

“35.2.Энэ хуулийн 35.1-д заасан магадлалыг маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.”



2 дугаар зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “өмгөөлөгч,” гэсний дараа “шүүгч,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.7 дахь заалтын “бусдад” гэсний дараа “хугацаа хэтэрсэн” гэж, мөн зүйлийн 11.6 дахь хэсгийн “олон нийтээс” гэсний дараа “хуульд заасан шаардлага хангасан хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.2.давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь тухайн шатны шүүхэд гурваас доошгүй жил ажилласан;”

4 дүгээр зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалтын “Ёс зүйн хорооны шийдвэр” гэснийг “захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал” гэж, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “Ёс зүйн хороо” гэснийг “Ёс зүйн хорооны гурван гишүүн” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “шийдвэрлэж магадлал гаргана” гэснийг “шийдвэрлэнэ” гэж, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “арга хэмжээг оногдуулахдаа” гэснийг “арга хэмжээ оногдуулсан тохиолдолд” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “2013 оны 7 дугаар сарын 01-ний” гэснийг “2013 оны 4 дүгээр сарын 15-ны” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “хоёроос гурван” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, 36.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:



1/18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг:

“18.6.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үед талуудын гаргасан аливаа тайлбар нь шүүхээр маргааныг хянан шийдвэрлэхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй.”

2/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Энэ хуулийн 30.2-т заасны дагуу талуудын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “дээр” гэсний дараа “орон тооны болон орон тооны бус” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эвлэрүүлэн зохицуулах” гэснийг “эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгчтэйгээр шийдвэрлэх” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “хэрэглэх нь зохистой гэж үзсэнээр” гэснийг “зохистой гэж үзэж санал болгосныг зөвшөөрснөөр” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “талууд болон эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд” гэснийг “талууд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эрх ашиг нь хөндөгдсөн гуравдагч этгээд болон бусад этгээд” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “74.5” гэснийг “74.6” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “2013 оны 7 дугаар сарын 01-ний” гэснийг “2013 оны 4 дүгээр сарын 15-ны” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “2013 оны 7 дугаар сарын 01-ний” гэснийг “2013 оны 4 дүгээр сарын 15-ны” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсгийн “Хуульчдын холбооны шүүгчдийн хороо” гэсний дараа “шүүгчийн ёс зүйн дүрмийг батлахаас гадна” гэж, 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн “2014 оны 01 дүгээр сарын 01-ний” гэснийг “2013 оны 4 дүгээр сарын 15-ны” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Зарим хууль, тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн зарим хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн хууль санаачлагч нь өөрчлөгдсөн, зарим төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын санал авах шаардлагатай байгаа зэргийг харгалзан хавсралтад дурдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



Монгол Улсын Их Хурлын 2013 оны
01 дүгээр тогтоолын хавсралт

**ХУУЛЬ САНААЧЛАГЧИД НЬ БУЦААХ ХУУЛЬ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН
ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалай, 2006.05.10/;

2. “Төрийн албаны гавьяат ажилтан” цол бий болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Ц.Сүхбаатар нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2008.02.01/;

3. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр, 2008.05.22/;

4. “Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 161 дүгээр конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг зөвшилцөх /Засгийн газар, 2008.10.10/;

5. “Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 81 дүгээр конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг зөвшилцөх /Засгийн газар, 2008.10.10/;

6. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Сугалаа зохион байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Н.Батбаяр нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2008.11.07/;

7. “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон малчдын арилжааны банкинд төлөх зээл, зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Г.Батхүү нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2009.03.25/;

8. Монгол Улсын Их Хурлын тухай /Шинэчилсэн найруулга/, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд /Х.Тэмүүжин нарын Улсын Их Хурлын 16 гишүүн, 2009.07.07/;



9.Монгол Улсын Эрүүгийн (Төрөлжсөн) хууль, Монгол Улсын Эрүүгийн (Төрөлжсөн) хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд /Ш.Сайхансамбуу нарын Улсын Их Хурлын 12 гишүүн, 2010.01.26/;

10.Казиногийн хуулийн төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд /Д.Загджав нарын Улсын Их Хурлын 10 гишүүн, 2010.03.11/;

11.Төрийн дээд цол, одон, медалийн тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зарим зарлиг, тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Монгол Улсын цол, Төрийн шагнал, одон медалийн тодорхойлолт батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Ш.Сайхансамбуу нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2010.03.25/;

12.Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Д.Дамба-Очир нарын Улсын Их Хурлын 9 гишүүн, 2010.03.29/;

13.Нийслэлийн эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар, 2010.04.07/;

14.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн/ /Ц.Батбаяр нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2010.05.24/;

15.Хүүхдэд мөнгөн тэтгэмж олгох тухай хуулийн төсөл болон “Мөнгөн тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Д.Оюунхорол нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2010.06.22/;

16.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны



тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч, 2010.07.08/;

17.Бэлчээрийн тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Р.Буд нарын Улсын Их Хурлын 19 гишүүн, 2010.07.08/;

18.“Хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /А.Тлейхан нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2010.08.12/;

19.“Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /С.Бямбацогт нарын Улсын Их Хурлын 9 гишүүн, 2010.10.27/;

20.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, 2011.01.06/;

21.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл, 2011.01.06/;

22.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Ц.Сэдванчиг нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2011.01.14/;

23.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд /Ж.Батсуурь нарын Улсын Их Хурлын 6 гишүүн, 2011.01.27/;

24.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүд болон “Алслагдсан болон говийн бүсд хамаарагдах сумдыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /С.Бямбацогт нарын Улсын Их Хурлын 30 гишүүн, 2011.04.12/;

25.“Дархан цаазат газрын нутаг дэвсгэрээс зарим газрыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Л.Гүндалай нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2011.06.21/;



26.Монгол Улсын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Багц хууль/ хуулийн төсөл /Засгийн газар, 2011.10.07/;

27.Газрын тос, ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /С.Оюун нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2011.11.01/;

28.Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Н.Батбаяр нарын Улсын Их Хурлын 43 гишүүн, 2011.12.06/;

29.Үндэсний их баяр наадмын тухай /Шинэчилсэн найруулга/, Үндэсний их баяр наадмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд, /Г.Батхүү нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2011.12.19/;

30.““Эрдэнэс-Таван толгой” Хувьцаат компанийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх болсонтой холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Ц.Дашдорж нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2011.12.20/;

31.“Хүний эрхийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль зүйн байнгын хороо, 2012.01.03/;

32.Монгол Улсын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Багц хууль/ хуулийн төсөл /Засгийн газар, 2012.01.31/;

33.Худалдааны тухай, Худалдааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар, 2012.01.31/;

34.Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Д.Лүндээжанцан нарын Улсын Их Хурлын 11 гишүүн, 2012.02.02/;

35.Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /З.Энхболд нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2012.02.09/;



36.“Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Я.Батсуурь нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2012.02.10/;

37.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Х.Баттулга нарын Улсын Их Хурлын 12 гишүүн, 2012.03.05/;

38.Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Я.Батсуурь, П.Алтангэрэл, 2012.03.14/;

39.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онц байдлын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч, 2012.03.23/;

40.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч, 2012.03.23/;

41.Улс төрийн намын тухай /Шинэчилсэн найруулга/, Улс төрийн намын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /З.Алтай нарын Улсын Их Хурлын 6 гишүүн, 2012.03.23/;

42.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар, 2012.04.02/;

43.Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Р.Буд нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2012.04.11/;

44.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Одхүү, 2012.04.24/;

45.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /П.Алтангэрэл нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2012.04.19/;

46.Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Я.Батсуурь нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2012.04.26/;

47.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Ж.Сүхбаатар нарын Улсын Их Хурлын 7 гишүүн, 2012.05.02/;

48.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Н.Батбаяр нарын Улсын Их Хурлын 3 гишүүн, 2012.05.03/;

49.Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр, 2012.05.11/;

50.Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч, 2012.06.18/;

51.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Р.Раш нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2012.07.04/;

52.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл, Ц.Цолмон, 2012.08.21/;

53.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Ц.Оюунгэрэл нарын Улсын Их Хурлын 4 гишүүн, 2012.10.03/;



54.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Р.Гончигдорж нарын Улсын Их Хурлын 5 гишүүн, 2012.10.15/.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эхлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай:

1/Хадгаламжийн даатгалын корпорацийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасны дагуу 2013 оны 02 дугаар сарын 10-ны дотор байгуулах;

2/банкуудыг хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд хамруулах арга хэмжээ авах;

3/Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 10.2.2, 10.2.3-т заасан хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд шаардлагатай 100.0 тэрбум төгрөгийн 50.0 тэрбум төгрөгийг Засгийн газраас, 50.0 тэрбум төгрөгийг Монголбанкнаас тус тус гаргаж, мөн хуулийн 19.5-д заасны дагуу Монголбанкинд нээсэн Хадгаламжийн даатгалын корпорацийн дансанд төвлөрүүлэх;

4/2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн 2.5-д заасан шимтгэлийг төвлөрүүлж, төвлөрсөн хөрөнгийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 19.5-д заасны дагуу Монголбанкинд нээсэн Хадгаламжийн даатгалын корпорацийн дансанд 2013 оны 8 дугаар сарын 01-ний дотор шилжүүлэх.



2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

**Шүүхийн тухай багц хуулийг дагаж
мөрдөх журмын тухай хууль батлагдсантай
холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангахад шаардагдах нэмэлт зардлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4-т заасан Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**Төрийн албаны зөвлөлийн гишүүний
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Өөрийнх нь хүсэлтийг харгалзан Дашбалын Батбаярыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүний үүрэгт ажлаас 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Тогмидын Хадхүүг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ЗАРЛИГ БОЛГОХ** нь:



Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржпаламын Гэрэлийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Баасанжавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 01 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

**Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кадырийн Сайрааныг эгүүлэн татаж, Кувейт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содномын Энхбатыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Барилгын тухай хуулийн 5.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.



2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 72 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 325 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2012 оны 151 дүгээр
тогтоолын хавсралт

**БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ,
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, их засвар хийх Барилгын тухай хуулийн 3.1.4-т заасан инженерийн хийцтэй бүх төрлийн байгууламж (цаашид “барилга байгууламж” гэх)-ийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад мөрдөнө.

1.2. Энэ дүрэмд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “барилгын ажил эхлүүлэх” гэж Барилгын тухай хуулийн 13.2, 13.3-т заасны дагуу барилгын норм, нормативын баримт бичгийг баримтлан боловсруулж, магадлал хийсэн зураг төслөөр баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх хуулийн этгээдэд барилгын ажил эхлүүлэх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг;

1.2.2. “барилгын ажил үргэлжлүүлэх” гэж тухайн барилга байгууламжид үүссэн тодорхой нөхцөл, шалтгааны улмаас (хөрөнгө оруулагч, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагын шийдвэр, дүгнэлт гэх мэт) 1 сараас дээш хугацаагаар барилгын ажил зогссон шалтгаан болон зөрчил дутагдлыг арилгасан талаар үйл ажиллагааг нь зогсоосон байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосноор барилгын ажил үргэлжлэх үйл ажиллагааг;

1.2.3. “барилга байгууламжийг ашиглалтад оруулах” гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (цаашид “комисс” гэх)-ын бүх гишүүд уг комиссын актад гарын үсэг зурж, баталгаажуулан, актын дугаар, барилга байгууламжийн паспорт олгосноор тухайн барилга байгууламжийг ашиглаж эхлэх үйл ажиллагааг.

Хоёр. Барилгын ажил эхлүүлэх үйл ажиллагаа

2.1. Барилгын ажлыг эхлүүлэх хүсэлтийг хөрөнгө оруулагч нь захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан холбогдох байгууллагад тавина.

2.2. Барилга байгууламжийн газар олголт, төлөвлөлт, инженерийн шугам сүлжээтэй холбогдсон зөвшөөрлийн энэхүү дүрмийн 5 дугаар хавсралтын 1.1, 1.2, 1.3-т заасан үйл ажиллагааг аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын барилгын асуудал хариуцсан агентлагийн нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан 30-35 хоногт багтаан шийдвэрлэнэ.

2.3. Барилга байгууламжийн зориулалт, ач холбогдол, үйлчлэх хүрээ, хийц бүтээцийн онцлогоос хамааруулан энэхүү дүрмийн 3 дугаар хавсралтад заасан ангиллын дагуу барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг холбогдох байгууллага нь 3 хоногийн хугацаанд олгоно.

2.4. Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг энэхүү дүрмийн 4 дүгээр хавсралтын “А” гэсэн хэсэгт заасан бичиг, баримтыг мөн дүрмийн 3 дугаар хавсралтад заасан байгууллагын холбогдох албан тушаалтан хянасны үндсэн дээр дүрмийн 1 дүгээр хавсралтад заасан загварын дагуу барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөлд гарын үсэг зурж, баталгаажуулан хөрөнгө оруулагч болон захиалагчид эсхүл зөвлөх үйлчилгээ эрхлэгчид олгоно.

2.5. Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг тухайн барилга байгууламж баригдаж дуусах хүртэл хугацаагаар олгоно. Зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд ажил эхлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдоно. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан холбогдох байгууллагад дахин хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

2.6. Зөвшөөрөл олгогч нь барилгын ажлыг эхлүүлэх шаардлага хангагдаагүй бол энэ талаар тодорхой үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргагчид ажлын 3 хоногт багтаан албан бичгээр өгнө.



Гурав. Барилгын ажлыг үргэлжлүүлэх үйл ажиллагаа

3.1. Дор дурдсан тохиолдолд барилгын ажлыг зогссонд тооцно:

3.1.1. барилга байгууламжийн ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд ажил нь эхлээгүй;

3.1.2. барилгын ажил 1 сараас дээш хугацаагаар дараахь шалтгаанаар зогссон:

3.1.2.1. барилгын ажлыг зогсоох талаар хууль хяналтын байгууллагын шийдвэр гарснаар;

3.1.2.2. барилгын ажлыг зогсоох талаар салбарын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарснаар;

3.1.2.3. барилгын ажлыг захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн шийдвэрээр зогсоосон.

3.2. Энэ дүрмийн 3.1-д заасны дагуу барилгын ажил зогссон шалтгаан болон зөрчил дутагдлыг арилгасан талаар барилгын үйл ажиллагааг зогсоосон байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн ажил үргэлжлүүлэх зөвшөөрлийг холбогдох байгууллага 3 хоногт багтаан олгоно.

Дөрөв. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа

4.1. Барилгын тухай хуулийн 3.1.4-т заасан инженерийн хийцтэй бүх төрлийн байгууламж (цаашид “барилга байгууламж” гэх)-ийг ашиглалтад оруулах үйл ажиллагааны явцад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (цаашид “комисс” гэх) ажиллана.

4.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь энэ дүрмийн 3 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулна.

4.3. Барилга байгууламжийн зориулалт, онцлогоос хамааруулан тухайн барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, техник технологитой нь холбоотой салбарын төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг комиссын бүрэлдэхүүнд оруулна.



4.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийг захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч энэ дүрмийн 3 дугаар хавсралтад заасны дагуу комиссын үйл ажиллагааг зохион байгуулах байгууллагад хүргүүлнэ.

4.5. Захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч комисс ажиллуулах хүсэлт гаргахдаа энэхүү дүрмийн 4 дүгээр хавсралтын “Б” гэсэн хэсэгт заасан бичиг, баримт, холбогдох материалыг бүрдүүлсэн байна. Комиссын үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага баримт бичгийн бүрдлийг хянаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулна.

4.6. Зураг төсөл зохиогч, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч талууд хамтран тухайн барилга байгууламжид техникийн болон чанарын үзлэг, шалгалт хийж дотоодын хяналтын дүгнэлт гаргана. Энэхүү дүгнэлтийг энэ дүрмийн 4.5-д заасан материалд хавсаргасан байна.

4.7. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдааны бэлтгэлийг комиссын нарийн бичгийн дарга, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч хамтран зохион байгуулна.

4.8. Комиссын нарийн бичгийн дарга комиссын хуралдааныг зохион байгуулах, гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах, акт үйлдэх ажлыг хариуцна.

4.9. Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй бол комиссын даргад хуралдаан эхлэхээс 1 хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэн байна.

4.10. Комиссын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг барилга байгууламжийн захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч гаргаж гүйцэтгэлийг холбогдох байгууллагаар баталгаажуулсан байна.

4.11. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын актад дугаар олгох, мэдээллийн санг хөтлөх үйл ажиллагааг энэхүү дүрмийн 3 дугаар хавсралтад заасан барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

4.12. Комисс нь дараахь эрх, үүрэгтэй:

4.12.1. комисс нь Барилгын тухай хууль, барилгын норм, нормативын бичиг, баримтад заасан шаардлагыг хангасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үүрэг хүлээнэ;



4.12.2. комиссын гишүүдийн санал дүгнэлтийг үндэслэн эцсийн шийдвэр гаргана. Энэхүү шийдвэр нь Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна;

4.12.3. комисс гишүүдийн 2/3-оос доошгүй нь ирснээр ажиллана. Комиссын гишүүд мэргэжлийн чиглэлээрээ дараахь үүргийг гүйцэтгэж, санал дүгнэлтийг танилцуулж ажиллана:

4.12.3.1. барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, барилга угсралтын ажлын чанар болон хүний ажиллаж амьдрах таатай орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аюулгүй байдлыг хангасан эсэх талаар нарийвчлан шалгаж, дүгнэлт гаргах;

4.12.3.2. барилга байгууламжийн техникийн баримт бичгийн бүрдүүлэлтийг хийсэн ажилтай уялдуулан үзэх;

4.12.3.3. барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээний ажил нь, зураг төсөл, барилга техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, галын норм, дүрэм, стандартын шаардлагыг хангасан эсэхийг нарийвчлан шалгаж, үнэлэлт дүгнэлт гаргах;

4.12.3.4. өргөх байгууламж, суурилагдсан тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдал, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ явуулах, ашиглахад бэлэн эсэхийг шалгаж дүгнэх;

4.12.3.5. барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралт, засвар шинэчлэлтийн ажлыг дутуу буюу чанаргүй хийсэн, хууль тогтоомж, норм, дүрмийн заалт, стандартын шаардлага зөрчсөн бол комисс ажиллахыг тодорхой хугацаагаар хойшлуулах, ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх.

4.12.4. шаардлага хангахгүй үйл ажиллагаа явуулсан, Барилгын тухай, Хот байгуулалтын тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, барилгын норм, нормативын бичиг, баримтын заалтыг ноцтойгоор зөрчсөн гүйцэтгэгч, зураг төслийн байгууллагын тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлуулах саналыг тусгай зөвшөөрөл олгогч байгууллагад тавина;

4.12.5. технологийн болон үйлдвэрлэл, үйлчилгээний харилцан уялдаагүй барилга байгууламжийг хэсэгчлэн ашиглах шийдвэрийг гаргана;



4.12.6. барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралт, засварын ажлыг дутуу буюу чанаргүй хийсэн, хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, техникийн нөхцөлийн заалтын шаардлага хангаагүй болон барилгын ажлын явц, чанарт тавигдсан хяналтад байгаа, тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ үзүүлсэн этгээд, зураг төсөл зохиогч, хангагч байгууллагаас тавьсан шаардлага, дүгнэлтийн биелэлтийг хангаагүй тохиолдолд комисс ажиллахаас татгалзах;

4.12.7. комиссын гишүүд мэргэжлийнхээ чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулна. Зөрчил дутагдлыг 14 хоногт бүрэн арилгасан байна. Комиссын актыг баталгаажуулаагүй тохиолдолд комисс дахин ажиллах бөгөөд үүнтэй холбогдож гарах зардлыг захиалагч хариуцна;

4.12.8. ашиглалтад оруулах барилга байгууламж нь Барилгын тухай, Хот байгуулалтын тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль болон бусад хууль, тогтоомж, барилгын норм, нормативын бичиг, баримтын заалтыг ноцтой зөрчсөн, зөрчлийг арилгах боломжгүй тохиолдолд энэ тухай эрх бүхий байгууллагад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санал хүргүүлэх.

4.12.9. ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн зураг төсөл, бичиг, баримтыг архивт хүлээлгэж өгөх, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх.

4.13. Захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч нь дараахь эрх үүрэгтэй:

4.13.1. комисс ажиллах нөхцөлийг хангаж гарах зардлыг хариуцах, шаардлагатай бол комисс томилсон байгууллагын дэмжлэг туслалцаа авах;

4.13.2. барилга байгууламжийн угсралтын ажил дутуу, чанаргүйгээс болж дахин комисс ажиллуулах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг хариуцах;

4.13.3. комиссын хуралдааны тэмдэглэл, комиссын өгсөн санал, дүгнэлтийн биелэлтийг гаргаж баталгаажуулах;

4.13.4. энэхүү дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан ил, далд ажлын гүйцэтгэлийн актууд (гарын үсэг, тамга тэмдэг бүрэн гүйцэд, бичилт бүрэн байх)-ыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар



баталгаажуулан, фото зургийг материалд хавсарган бичиг, баримтын товъёог хийсэн байх;

4.13.5. барилгын ажилд хэрэглэсэн түүхий эд, материал, бүтээц эдэлхүүний үйлдвэрийн паспорт, гарал үүсэл, тохирлын болон техникийн гэрчилгээ, чанарын баталгааг холбогдох ил, далд ажлын актад хавсаргасан байх;

4.13.6. барилгын ажлын үе шатны хяналтын болон захиалагч, зураг төслийн байгууллагын гаргасан акт, албан шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гүйцэтгэгчтэй хамтран гаргасан байх;

4.13.7. барилга байгууламжийн болон гадна, дотор инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг гарган материалд хавсаргах;

4.13.8. барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх явцын барилгын ажлын тэмдэглэл (талбайн журнал)-ийг зохих ёсоор хөтөлж захиалагчид хүлээлгэн өгөх;

4.13.9. комисс ажиллах үед зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг зураг төслийн байгууллагын хамт гаргаж, биелэлтийг хангуулах;

4.13.10. Барилгын тухай хуулийн 12.4-т заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш түүний чанар, аюулгүй байдлыг барилгын гүйцэтгэгч хариуцсан талаархи баталгаа гаргах.

“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах дүрэм”-ийн
1 дүгээр хавсралт

БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ

20 ... оны ... -р сарын ... -ны өдөр

№

Барилга байгууламж түүний туслах барилгуудын нэр төрөл, хүчин чадал,
хэмжээ, үндсэн хийц бүтээц



Захиалагчийн нэр (Зөвлөх үйлчилгээ эрхлэгч)

Газар олгосон шийдвэр (захирамж), байршил

Гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг

Зураг төсөл зохиогч байгууллагын нэр, хаяг, зургийн шифр

Захиалагч байгууллагын техникийн хяналт гүйцэтгэгчийн нэр, хаяг

Зөвшөөрөл олгосон үе шатны ажлын нэр:

Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа: _____

Зөвшөөрөл олгосон албан тушаалтан:

Овог нэр, гарын үсэг, тэмдэг _____

Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд: _____

Онцгойлон заах нөхцөл

Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл

ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАЛТ

20 ... оны ... -р сарын ... -ны өдөр

Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд: _____

Онцгойлон заах нөхцөл: _____

Зөвшөөрөл сунгасан ажлын нэр төрөл _____

Сунгасан хүчинтэй хугацаа _____



Хугацаа сунгасан байгууллагын нэр: _____

Хугацаа сунгасан албан тушаалтны:
Овог, нэр, хаяг, гарын үсэг, тэмдэг _____

“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах дүрэм”-ийн
2 дугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН АКТ

20 ... оны ... сарын ... -ны өдөр Дугаар ... Улаанбаатар хот
НЭГ

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал

1.2. Захиалагч аж ахуйн нэгж, байгууллага (Зөвлөх үйлчилгээ эрхлэгч)

1.3. Ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага

1.4. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага

1.5. Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага

1.6. _____

шийдвэрээр зохион байгуулсан __хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай захиалагч байгууллагын 20 ... оны ... сарын ... -ны өдрийн ... дугаар мэдэгдлийн дагуу 20... оны ... сарын ... -ны өдрөөс ...-ны өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл, шинэтгэл, их засварын ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэв.

1.7. Энэхүү барилга байгууламжийг ... дугаартай зураг төслөөр ... оны ... сараас барьж эхэлсэн бөгөөд ... оны ... сарын ... -ны өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР

2.1. Энэхүү _____



барилга байгууламж, холбогдох акт, баримтуудыг шалгаад ашиглалтад оруулах тухай комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН нь:

2.2. Энэхүү барилга байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж

зориулалтаар ашиглахад _____ гэж үзээд захиалагч (ашиглагч) байгууллага болох _____

мэдэлд 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс ашиглалтад (үйлдвэрлэл, үйлчилгээ, оршин суух зэрэг) оруулахыг зөвшөөрөв.

2.3. Комиссоос даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, холбогдох баримтуудын эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх.

Захиалагч (ашиглагч) байгууллагад:

А) Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт хийж байх;

Б) Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгыг хэвийн ашиглаж, засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

2.4. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн бичиг, баримтын жагсаалтыг хавсаргав.

(Тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ)

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Тайлбар: Энэхүү хуудсанд комисст ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ дээр нь тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.



“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 3 дугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛЛААР БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН КОМИСССЫН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Барилга байгууламжийн зориулалт, ач холбогдол, үйлчлэх хүрээ, хийц бүтээц | | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага | Ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн | | |
|---|---|---|---|--|---|---|
| | Барилгын төрөл | Инженерийн байгууламж болон инженерийн шугам сүлжээ | | Дарга | Нарийн бичгийн дарга | Гишүүд |
| 1 | Нэгдүгээр ангиллын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ | | | | | |
| | 1.1 Түүх, соёлын барилга | 1.9 Эрчим хүчний эх | Салбарын төрийн захиргааны төв байгууллага | Салбарын төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга | Салбарын төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтэн | 1. Захиалагч болон зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн төлөөлөл 2. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл 3. Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл 4. Архивын байгууллагын төлөөлөл 5. Ашиглалт |
| | 1.2 Цамхаг, тулгуур, тушиц хана зэрэг 30 м-ээс дээш өндөр, 60 м-ээс дээш алгасалттай байгууламж, 17-35 давхар (51 м - 150 м өндөр) хүртэл иргэний болон үйлдвэрийн бүх төрлийн барилга байгууламж | 1.10 Дулаан дамжуулах сүлжээ | | | | |
| | 1.3 Ган бүтээцэн барилгын ажил (тагангийн алгасал нь 30 м-с дээш, баганын өндөр нь 18 м-ээс дээш) | 1.11 Цахилгаан дамжуулах сүлжээ | | | | |
| | 1.4 Газар доорхи гарц, | 1.12 Цэвэр дамжуулах шугам | | | | |
| | | 1.13 Бохир ус татан зайлуулах шугам | | | | |
| | | 1.14 Төвлөрсөн цэвэрлэх байгууламж | | | | |
| | | 1.15 Үерийн зайлуулах байгууламж | | | | |

| | | | | | | |
|--|---|---|---|--|--|--|
| <p>Тусгай зориулалтын угсармал ба цутгамал төмөр бетон болон ган бүтээцтэй байгууламж</p> <p>1.5 Олон улсын болон улсын чанартай авто зам, зам гүүрийн байгууламж</p> <p>1.6 Их засвар, шинэчлэлт хийсэн олон улсын чанартай авто зам, замын байгууламж</p> <p>1.7 Цэрэг, батлан хамгаалах зориулалтын бүх төрлийн барилга байгууламж</p> <p>1.8 Далд уурхайн барилга байгууламж</p> | | | | | | <p>хариуцах байгууллагын төлөөлөл</p> <p>6. Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл</p> <p>7. Салбарын мэргэжлийн хяналт</p> <p>хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл</p> |
| <p>Хоёрдугаар ангиллын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ</p> | | | | | | |
| <p>2.1 Цамхаг тулгуур, түшиц хана зэрэг 30 м хүртэл өндөр, 60 м-ээс доош алгасалтай, 17 (51 м өндөр) хүртэл давхар иргэний үйлдвэрийн барилга байгууламж</p> <p>2.2 Ган бүтээцэн барилгын ажил алгасал нь 30 м, баганын өндөр нь 18 м хүртэл</p> <p>2.3 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө иргэний барилга болон амины орон сууцны хотхон, хорооллын</p> | <p>2.7 Дулаан сүлжээ</p> <p>2.8 Цахилгаан түгээх сүлжээ, холбогдох барилга байгууламж</p> <p>2.9 Цэвэр ус түгээх шугам, холбогдох барилга байгууламж</p> <p>2.10 Бохир ус цуглуулах шугам, холбогдох барилга байгууламж</p> <p>2.11 Бага оврын дулаан, цахилгаан эрчим хүч, цэвэр усны эх үүсвэрийн</p> | <p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа барилгын асуудал эрхэлсэн холбогдох газар, хэлтсийн дарга</p> | <p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа барилгын асуудал эрхэлсэн агентлагийн мөргөжилтэн</p> | <p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа барилгын асуудал эрхэлсэн агентлаг</p> | <p>1. Захиалагч болон зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн төлөөлөл</p> <p>2. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл</p> <p>3. Гүйцэтгэч байгууллагын төлөөлөл</p> <p>4. Архивын байгууллагын төлөөлөл</p> <p>5. Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл</p> | |

| | | | | | | |
|--|---|---|---|---|-------------------|---|
| | <p>Барилга 2.4 Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж 2.5 Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам, замын байгууламж 2.6 Их засвар, шинэчлэл хийсэн орон нутгийн чанартай авто зам, зам гүүрийн байгууламж</p> | <p>Барилга Ил далд, хийцтэй усралтын системийн барилга байгууламж 2.12 100 мян.м³-ээс том зээлхүүнтэй усан сан, хөв цөөрмийн боомт, далангийн барилга байгууламж</p> | | | | <p>Төлөөлөл 6. Аймаг, нийслэлийн онцгой байдлын газрын төлөөлөл 7. Аймаг, нийслэлийн салбарын мөргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл</p> |
| | <p>3 3.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт 3.2 Инженерийн хангамж нь өөрийн эх үүсвэртэй 2 давхар хүртэл, 3600 м³ зээлхүүнтэй иргений барилга болон амины орон сууцны инженерийн барилга 3.3 10 га хүртэл хүчин чадалтай бичил усралтын системийн барилга байгууламж</p> | <p>3.4 Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татууртын шугам сүлжээ тэдгээрийн тоног төхөөрөмж 3.5 Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн шугам сүлжээ тэдгээрийн тоног төхөөрөмж 3.6 Гадаргын, дуслын болон хөрсөн дотроос услах усалгааны тоног төхөөрөмж, ус дамжуулах шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, ус өргөх шахуурга, ус нөөцлөх сав</p> | <p>Захиалагч болон зөвлөх үйлчилгээ үзүүлсэн этгээд</p> | <p>Захиалагч болон зөвлөх үйлчилгээ үзүүлсэн этгээд</p> | <p>Гүйцэтгэгч</p> | <p>1. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл 2. Архивын байгууллагын төлөөлөл 3. Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл</p> |



“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн
4 дүгээр хавсралт

БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
АВАХ БОЛОН АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД БҮРДҮҮЛСЭН БАЙХ
ШААРДЛАГАТАЙ БИЧИГ, БАРИМТЫН ЖАГСААЛТ

| № | Бүрдүүлсэн байх бичиг, баримт (I болон II ангиллын барилга) | |
|--|--|----------------|
| А. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлсэн байх бичиг, баримт | | |
| 1. | Зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл | |
| 2. | Барилгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ (тухайн ажлыг гүйцэтгэх хүрээнд тохирсон) | |
| 3. | Магадлал хийгдсэн тухайн барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл | |
| 4. | Барилга байгууламжийн угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгэх Барилгын тухай хуулийн 3.1.12-т заасан инженер техникийн ажилтныг томилсон шийдвэр | |
| 5. | Захиалагч (хөрөнгө оруулагч)-ийн техникийн хяналт гүйцэтгэх болон зохиогчийн хяналт хийх гэрээ | |
| 6. | Барилга байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээ | |
| 7. | Барилгын талбайн зохион байгуулалтын зураг болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны ажил гүйцэтгэх төслийн бичиг, баримт | |
| Дээрх бичиг, баримтаас гадна зөвшөөрөл олгогч нь захиалагч (хөрөнгө оруулагч)-аас дор дурдсан нэмэгдэл материалыг авч болно: | | |
| 8. | Барилга байгууламжийн угсралтын ажил нь удаан хугацаагаар зогссон болон хуучин барилгад шинэчлэлт хийх үед салбарын мэргэжлийн хяналтын байгууллага болон зөвлөх үйлчилгээ эрхлэгчийн гаргасан дүгнэлт | |
| Б. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахын өмнө бүрдүүлсэн байх бичиг, баримт | | |
| 1. | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл | |
| 2. | Зураг төслийн байгууллагаар гаргуулсан зохиогчийн нэгдсэн дүгнэлт | |
| 3. | Барилгын тухай хуулийн 12.4-т заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш түүний чанар, аюулгүй байдлыг барилгын гүйцэтгэгч хариуцсан талаархи баталгаа | |
| 4. | Захиалагч, зохиогч, гүйцэтгэгч байгуулагууд барилга байгууламжийн угсралт, тоног төхөөрөмжийн ажлын чанарыг хамтран шалгасан гүйцэтгэлийн акт (УББ 12-01-01) | |
| 4.1. | Ил, далд ажлын бүрдүүлэх акт, техникийн бичиг, баримт | Маягтын дугаар |
| 4.1.1. Барилга угсралтын ажлын акт (M1-M48) | | |
| 1. | Улаан шугамыг шалгаж тэг, тэнхлэг татсан акт | M-1 |
| 2. | Суурийн нүх ухсан акт | M-2 |
| 3. | Суурийн ажил гүйцэтгэсэн акт | M-3 |
| 4. | Өрөгт бүтээцийн ажил гүйцэтгэсэн акт | M-4 |
| 5. | Хана сууринд төмөр бетон бүс хийсэн акт | M-5 |



| | | |
|-----|---|------|
| 6. | Цутгамал бетон, төмөр бетон бүтээцийн ажил гүйцэтгэсэн акт | M-6 |
| 7. | Угсармал бетон, төмөр бетон бүтээцийн ажил гүйцэтгэсэн акт | M-7 |
| 8. | Хананд салхивч, утааны сүвгийн ажил гүйцэтгэсэн акт | M-8 |
| 9. | Төмөр бүтээцийг угсарч гагнасан акт | M-9 |
| 10. | Дотор халаалтын системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | M-10 |
| 11. | Дотор бохир усны системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | M-11 |
| 12. | Гадна бохир усны системийг угсарсан, шалгасан акт | M-12 |
| 13. | Дотор халуун, хүйтэн усан хангамж, гал эсэргүүцэгч системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | M-13 |
| 14. | Гадна дулаан, цэвэр усан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | M-14 |
| 15. | Халаалтын тогоо, түүний тоног төхөөрөмжүүдийг угсарсан, сорилтоор шалгасан акт | M-15 |
| 16. | Дулааны зангилгаа, ус халаагчийг угсарсан акт | M-16 |
| 17. | Барилгын салхивчийн системийг угсарч, сорилт хийсэн акт | M-17 |
| 18. | Модон бүтээцийн ажил гүйцэтгэсэн акт | M-18 |
| 19. | Дээврийн ажил гүйцэтгэсэн акт | M-19 |
| 20. | Цутгамал төмөр бетон бүтээцийг арматурласан акт | M-20 |
| 21. | Тагт, карнизын төмөр бетон хавтанг бэхэлсэн акт | M-21 |
| 22. | Дуу, дулаан тусгаарлалтын ажил гүйцэтгэсэн акт | M-22 |
| 23. | Шалны ажил гүйцэтгэсэн акт | M-23 |
| 24. | Заслын ажил гүйцэтгэсэн акт | M-24 |
| 25. | Барилгын гадна цахилгааны кабелийн ажил гүйцэтгэсэн акт | M-25 |
| 26. | Дотор цахилгааны угсралтын ажил гүйцэтгэж түршилтаар шалгасан акт | M-26 |
| 27. | Тоног төхөөрөмжийн суурь хийсэн болон тоног төхөөрөмжийг байрлуулж угсарсан акт | M-27 |
| 28. | Тоног төхөөрөмжид цахилгаан холболт, газардуулга хийсэн акт (нэг бүрээр) | M-28 |
| 29. | Тоног төхөөрөмжүүдэд контур газардуулга хийсэн, шалгасан акт | M-29 |
| 30. | Барилгад аянга зайлуулагч хийсэн, туршсан акт | M-30 |
| 31. | Ган бүтээцийн угсралтын ажил гүйцэтгэсэн акт | M-31 |
| 32. | Хүн, тээш зөөврийн лифтийн тоног төхөөрөмжийг угсарсан, шалгаж туршсан акт | M-32 |
| 33. | Лифтийн цахилгаан холболтыг хийсэн, шалгасан акт | M-33 |
| 34. | Лифтийг гүйцэтгэгч байгууллагаас хүлээлгэж өгсөн акт | M-34 |
| 35. | Гадна зам, талбайн тохижилтын ажил гүйцэтгэсэн акт | M-35 |
| 36. | Барилга байгууламжийн геодезийн ажлыг хүлээлцсэн акт | M-36 |
| 37. | Төмөр бетон зүрхэвч цутгасан акт | M-37 |



| | | |
|--|---|------|
| 38. | Хаалга цонхны ялууг суулгасан акт | M-38 |
| 39. | Угсармал төмөр бетон дам нуруу, багана угсарсан акт | M-39 |
| 40. | Цонх суулгах ажил гүйцэтгэсэн акт | M-40 |
| 41. | Хаалга суулгах ажил гүйцэтгэсэн акт | M-41 |
| 42. | Галын шат угсарсан акт | M-42 |
| 43. | Урсдаг шат угсарсан акт | M-43 |
| 44. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу орц гарц хийсэн акт | M-44 |
| 45. | Тоног төхөөрөмжийн суурь хийсэн болон тоног төхөөрөмжийг байрлуулж угсарсан акт | M-45 |
| 46. | Тоног төхөөрөмжинд туршилт хийсэн акт (а, б) | M-46 |
| 47. | Уур, ус тусгаарлалтын ажил хийсэн, шалгасан акт | M-47 |
| 48. | Гадна зам талбай, тохижилт хийсэн акт | M-48 |
| 49. | Барилга угсралтын явцад өөрчилсөн болон бусад шийдвэрлэсэн асуудлуудад холбогдох бичиг, баримтуудын хуулбар буюу эх материал | |
| 50. | Зураг төсөл зохиогч болон мэргэжлийн хяналтын байгууллагуудаас шалгаад гарсан акт, шаардлага түүний биелэлт | |
| 51. | Зураг төслөөс өөрчилж хийсэн зүйлийн жагсаалт, түүнийг хэрхэн өөрчилсөн талаархи тодорхойлолтууд | |
| 52. | Инженерийн шугам сүлжээ болон даацын үндсэн бүтээцийн гүйцэтгэлийн зураг | |
| 53. | Барилгын ажлын өдөр тутмын тэмдэглэлийг архивт хадгалах хувьд хавсаргана. | |
| 4.1.2. Авто зам, гүүрийн барилга байгууламжийг гүйцэтгэх явцад бүрдүүлэх бичиг, баримт (M49-M57) | | |
| 54. | Зам, гүүрийн тэнхлэг тавьсан акт, түүнийг тавихад гаргасан зай, хэмжээний зураглал | M-49 |
| 55. | Удирдах болон зураг төсвийн хяналтын байгууллагаас өгсөн шаардлага, акт, дүгнэлт тэдгээрийн биелэлт | M-50 |
| 56. | Лабораторийн шинжилгээний дүгнэлтүүд | M-51 |
| 57. | Гүйцэтгэлийн зураг, үндсэн болон туслах реперийг хүлээн авах | M-52 |
| 58. | Авто замын хувьд Бамп интеграториар хэмжсэн тэгш байдлын үзүүлэлт, график, төмөр замын хувьд "1520 мм-ийн царигтай төмөр зам стандартын"-ын дагуу шинээр барьсан замыг тогтворжуулах ачааг нэвтрүүлсэн тухай акт, зам хэмжигч вагоны хэмжилтийн тууз дүгнэлт | M-53 |
| 59. | Карьер, орд газруудыг буцаан дарсан акт | M-54 |
| 60. | Зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох үзүүлэлтүүдийг шалгах (замын тэгш байдал, хучилтын бат бэх, гадаргуугийн гулсалтын эсэргүүцэл, гадаргуугийн дугуй мөрний хотойлт, гадаргуугийн барзгаржилт, далан суурийн даац, хурдны хангалт г.м) | M-55 |
| 61. | Авто зам, төмөр зам, замын байгууламжуудын далд гүйцэтгэсэн ажлын акт | M-56 |



| | | |
|--|---|------|
| 62. | Авто зам, төмөр зам, гүүрийн байгууламжийг гүйцэтгэх явцад бүрдүүлэх баримт бичиг | M-57 |
| 4.1.3. Эрчим хүчний барилга байгууламж шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг угсрахад бүрдүүлэх бичиг, баримт (M58-M99) | | |
| 63. | Зураг төслөөс өөрчлөгдөн хийгдсэн ажлын жагсаалт | M-58 |
| 64. | Техникийн бичиг, баримт | M-59 |
| 65. | Дутуу ажлын жагсаалт | M-60 |
| 66. | Кабелийг хүйтний улиралд сунгахын өмнө халаасан протокол | M-61 |
| 67. | Кабель шугамыг шулуутгасан өндөр хүчдэлээр шалгасан протокол | M-62 |
| 68. | Цахилгаан дамжуулах агаарын шугамын паспорт | M-63 |
| 69. | Тулгуурын далд ажлын акт | M-64 |
| 70. | Трансформаторын дэд станцын паспорт | M-65 |
| 71. | Цэнэг шавхагч шалгасан протокол | M-66 |
| 72. | Хуурай салгуур шалгасан протокол | M-67 |
| 73. | Газардуулах байгууламжийн паспорт | M-68 |
| 74. | Газардуулгын хүрээний эсэргүүцэл шалгасан протокол | M-69 |
| 75. | 1000 ква-гаас бага чадлын хүчний трансформаторт туршилт хийсэн протокол | M-70 |
| 76. | Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн үзүүлэлтүүд: 1. Төмөр бетон тулгуур 2. Суурь 3. Тусгаарлагч 4. Утасны бэхлэгээний тоноглолууд 5. Хэт хүчдэлийн хамгаалалт 6. Агаарын шугамын газардуулга | M-71 |
| 77. | Гарц ба огтлол Гарц ба огтлолын үзлэгийн акт Дэд станцын холбооны төхөөрөмжүүд Бусад тэмдэглэл | M-72 |
| 78. | Төмөр тулгуурын суурь угсрах ажлын журнал | M-73 |
| 79. | Төмөр бетон тулгуур угсралтын журнал | M-74 |
| 80. | Төмөр тулгуурын угсралтын ажлын протокол | M-75 |
| 81. | Анкерийн алгасалтын утас угсралтын ажлын журнал | M-76 |
| 82. | Тулгуурын газардуулгын хүрээний эсэргүүцэл хэмжсэн протокол | M-77 |
| 83. | Хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжийн жагсаалт | M-78 |
| 84. | Тосон хийц таслуур шалгасан протокол | M-79 |
| 85. | Цахилгаан тоног төхөөрөмжийн тосонд туршилт хийсэн протокол | M-80 |
| 86. | Хуваарилах байгууламжид туршилт хийсэн протокол | M-81 |
| 87. | Цахилгаан тоног төхөөрөмжийн тосонд хатаалт хийсэн протокол | M-82 |



| | | |
|---|--|-------|
| 88. | Хуваарилах байгууламжийн далд ажлын акт | М-83 |
| 89. | Шиний холболт шалгасан тухай протокол | М-84 |
| 90. | Дотоод цахилгаан холболтын далд ажлын акт | М-85 |
| 91. | Гэрэлтүүлгийн ажил хийсэн тухай акт | М-86 |
| 92. | Дэд станцын төмөр бүтээц гaгнсан тухай акт | М-87 |
| 93. | Хүчний трансформаторт хийсэн туршилт, сорилтын ажлын протокол | М-88 |
| 94. | Хоёрдогч хэлхээний угсралтын ажлыг шалгасан протокол | М-89 |
| 95. | Дулааны шугамын улаан шугам татсан акт | М-90 |
| 96. | Дулааны шугам хоолойн далд ажлын акт | М-91 |
| 97. | Камерийн далд ажлын акт | М-92 |
| 98. | Гадна дулаан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан акт | М-93 |
| 99. | Дулааны шугам хоолойг угсарч, хүлээн авсан акт | М-94 |
| 100. | Шугам хоолойн угаалга хийсэн акт | М-95 |
| 101. | Дулааны шугам хоолойн бат бэх, нягтын байдлыг туршиж шалгасан тухай акт | М-96 |
| 102. | Компенсаторын таталтыг хийсэн тухай акт | М-97 |
| 103. | Даралтат савыг угсарсан болон түүний нягтыг шалгасан акт | М-98 |
| 104. | Зуух, даралтат сав шугам хоолойн угсралтын үед хийгдэх гагнуурын ажилд бүрдүүлэх материалууд | М-99 |
| 4.1.4. Харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг угсрахад бүрдүүлэх бичиг, баримт (М100-107) | | |
| 105. | Холбооны кабель шугамын сувагчлалын угсралтын далд ажлын акт | М-100 |
| 106. | Кабелийн шөрмөсийн залгааг модуль коннектороор хийсэн байдлыг шалгасан акт | М-101 |
| 107. | Холбооны кабель шугамын байгууламжийг сүлжээнд холбох техникийн акт | М-102 |
| 108. | Радионы дотор угсралт хийсэн, шалгасан акт | М-103 |
| 109. | Телефоны дотор угсралт хийсэн, шалгасан акт | М-104 |
| 110. | Радионы гадна холболтын угсралт хийсэн, шалгасан акт | М-105 |
| 111. | Телефоны гадна холболтын угсралт хийсэн, шалгасан акт | М-106 |
| 112. | Шилэн кабелийн угсралтыг ашиглалтад хүлээн авах акт | М-107 |

Тайлбар: Актуудыг дагалдуулан уг ажилд хэрэглэсэн материалын лабораторийн шинжилгээний дүгнэлт, дагалдах сертификат, бусад бичиг, баримтуудыг хавсаргасан байна.



“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,
ашиглалтад оруулах дүрэм”-ийн
5 дугаар хавсралт

**БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ**

| Үйл ажиллагаа | Шаардагдах хугацаа (ажлын хоног) | |
|---|-------------------------------------|---------|
| А. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа | | |
| Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийн 3 дугаар хавсралтын I болон II ангиллын барилга | | |
| 1. Орон нутгийн нэг цэгийн үйлчилгээ | | |
| 1.1. Газар эзэмших хүсэлт гаргах | 30-35 хоног | |
| 1.1.1. Газар олгох Засаг даргын захирамж гаргах | | |
| 1.1.2. Газрын байршлын кадастрын зураг, Газар эзэмших гэрээ, гэрчилгээ олгох | | |
| 1.2. Барилга барих хүсэлт гаргах | | |
| 1.2.1. Архитектур төлөвлөлтийн даалгавар | | |
| 1.2.2. Эскиз батлах | | |
| 1.3. Техникийн нөхцөл олгох | | |
| 1.3.1. Дулааны техникийн нөхцөл олгох | | |
| 1.3.2. Усны техникийн нөхцөл олгох | | |
| 1.3.3. Цахилгааны техникийн нөхцөл олгох | | |
| 1.3.4. Холбооны техникийн нөхцөл олгох | | |
| 2. Барилгын зураг төсөлд магадлал хийх | | |
| 2.1. Магадлал хийгдсэн зураг төслийг баталгаажуулах | | 7 хоног |
| 3. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийн 3 дугаар хавсралтад заасан байгууллага зөвшөөрөл олгох | | |
| 3.1. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох | 3 хоног | |
| Б. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа | | |
| 4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь энэ дүрмийн 3 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр энэ дүрмийн 4.12.7-д заасан хугацаанд ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулна. | | |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

**Протез, ортопедийн болон тусгай
хэрэгслийн жишиг үнийг тогтоох тухай**

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.2, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнийн жагсаалтыг хавсралт ёсоор баталж 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Үнэ, тариф болон амьжиргааны өртгийн өөрчлөлтийг харгалзан протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жишиг үнийн хэмжээнд тухай бүр өөрчлөлт оруулах талаар санал боловсруулан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлж байхыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

Засгийн газрын 2012 оны 153 дугаар
тогтоолын хавсралт

**ПРОТЕЗ, ОРТОПЕДИЙН БОЛОН ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙН
ЖИШИГ ҮНИЙН ЖАГСААЛТ**

| № | Хэрэгслийн нэр | Үнэ (төгрөгөөр) |
|-------------------------------|---------------------------------------|-------------------|
| А-1 ДООД МӨЧНИЙ ПРОТЕЗ | | |
| 1 | Шилбэ, тавхайн протез | 400.000 |
| 2 | Дунд чөмөгний протез | 500.000 |
| 3 | Сүүж, түнхний протез | 650.000-1.000.000 |
| 4 | Тавхайн урд хэсгийн протез (башмачок) | 50.000-120.000 |
| 5 | Өвдөгний тулгууртай шилбэний протез | 500.000 |
| 6 | Хиймэл түнхний үе | 6.000.000 |
| 7 | Хиймэл өвдөгний үе | 5.000.000 |
| 8 | Шилбэний түгжээт хадаас | 450.000 |
| А-2 ДЭЭД МӨЧНИЙ ПРОТЕЗ | | |
| 9 | Мөр, бугалганы протез | 400.000 |
| 10 | Шууны протез | 300.000 |



| | | |
|-------------------------------------|---------------------------------------|-----------------|
| 11 | Сарвууны протез | 150.000 |
| 12 | Гарын хурууны протез | 30.000-100.000 |
| А-3 ПРОТЕЗИЙН БУСАД ХЭРЭГСЭЛ | | |
| 13 | Гавлын титан бүрхэвч | 1.200.000 |
| 14 | Хиймэл эрүү | 180.000 |
| 15 | Шилэн нүд | 50.000-85.000 |
| 16 | Хиймэл шүд | 20.000-120.000 |
| 17 | Нүдний уян болор (зөөлөн) | 275.000-460.000 |
| 18 | Зүрхний хиймэл хавхлага | 3.000.000 |
| Б-1 СОГОГ ЗАСАХ ГУТАЛ | | |
| 19 | Өвлийн гутал (захиалгаар хийх) | 150.000 |
| 20 | Өвлийн гутал (стандартын) | 300.000 |
| 21 | Хавар, намрын гутал (захиалгаар хийх) | 120.000 |
| 22 | Хавар, намрын гутал (стандартын) | 250.000 |
| 23 | Зуны гутал | 120.000 |
| Б-2 ТӨРӨЛ БҮРИЙН УЛАВЧ | | |
| 24 | Өндөрлөгтэй улавч | 50.000 |
| 25 | Пронатор, супинатор улавч | 25.000 |
| Б-3 НУРУУНЫ ХАМГААЛАЛТ | | |
| 26 | Нурууны ширэн хамгаалалт | 65.000-150.000 |
| 27 | Нурууны даавуун хамгаалалт | 60.000 |
| 28 | Нурууны хуванцар хамгаалалт | 250.000 |
| 29 | Нурууны бэхэлгээ | 600.000 |
| Б-4 ТӨРӨЛ БҮРИЙН ЧИГ | | |
| 30 | Хөлийн чиг бүхий аппарат (урт) | 300.000 |
| 31 | Хөлийн чиг бүхий аппарат (богино) | 200.000 |
| 32 | Гарын чиг (төрлөөсөө хамааран) | 50.000-150.000 |



| | | |
|--------------------------------------|--|----------------|
| 33 | Шууны чиг | 50.000 |
| 34 | Бугалганы чиг | 150.000 |
| 35 | Шагайн чиг | 90.000 |
| 36 | Хүзүүвч | 50.000 |
| 37 | Суга өргөгч чиг | 80.000-150.000 |
| 38 | Хүзүүний бэхэлгээ (хатуу) | 50.000 |
| 39 | Хүзүүний бэхэлгээ (зөөлөн) | 30.000 |
| Б-5 ОРТОПЕДИЙН БУСАД ХЭРЭГСЭЛ | | |
| 40 | Павликийн дөрөөвч (захиалгаар хийх) | 25.000-50.000 |
| 41 | Павликийн дөрөөвч (стандарт) | 50.000 |
| 42 | Ивэрхийн даруулга | 30.000 |
| 43 | Бөөрний бандааж | 20.000 |
| В-1 ТӨРӨЛ БҮРИЙН ТАЯГ | | |
| 44 | Модон таяг (хос) | 15.000 |
| 45 | Төмөр суга таяг (хос) | 40.000 |
| 46 | Тохойн тулгууртай таяг (хос) | 40.000 |
| 47 | Гар таяг | 10.000 |
| 48 | Цагаан таяг (хараагүй хүний) | 60.000 |
| 49 | Мэдрэгчтэй цагаан таяг (хараагүй хүний) | 120.000 |
| В-2 БУСАД ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ | | |
| 50 | Алхуулагч (насанд хүрэгсэд) | 50.000 |
| 51 | Тэргэнцэр (насанд хүрэгсэд) | 150.000 |
| 52 | Хөтөвч,суултуур (насанд хүрэгсэд) | 80.000 |
| 53 | Насанд хүрэгсдийн stom-ийн уут (50 ширхэг) | 720.000 |
| В-3 ХҮҮХДИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ | | |
| 54 | Тэргэнцэр (энгийн) | 200.000 |



| | | |
|--------------------|--|---------------|
| 55 | Тэргэнцэр (атгагч, ширээ, түшдэг, хэвтдэг хүзүүвчтэй) | 600.000 |
| 56 | Хүүхдийн цээживч | 400.000 |
| 57 | Эмчилгээний бөмбөг (зуйван) | 80.000 |
| 58 | Эмчилгээний бөмбөг (бөөрөнхий) | 60.000 |
| 59 | Хүүхдийн алхуулагч | 120.000 |
| 60 | Тамбформ(саажилттай хүүхдийг хэвтүүлэхэд ивдэг олон төрлийн хэлбэр бүхий зөөлөвч ивээс) | 50.000 |
| 61 | Гарын анчер (саажилттай хүүхдийг бие засахад суулгаж тогтоодог чиглүүлэгч) | 280.000 |
| 62 | Зогсоогч | 160.000 |
| 63 | Тавцантай ширээ | 160.000 |
| 64 | Гар, хөлийн спилен (бугуй тэгшлэгч, эрхий салгагч) | 35.000 |
| 65 | Хөтөвч ,суултуур | 12.000 |
| 66 | Stom-ийн уут (50 ширхэг) | 720.000 |
| B-4 Бусад хэрэгсэл | | |
| 67 | Хараагүй хүний брайлийн хэрэгсэл (брайль цаас 300 ширхэг, брайль шугам, бичгийн машин, брайль тэмдэглэлийн дэвтэр) | 100.000 |
| 68 | Дизи тоглуулагч (хараагүй хүний ярьдаг ном унших) | 520.000 |
| 69 | Сонсголын дижитал аппарат | 350.000 |
| 70 | Дунд чихний титан протез | 350.000 |
| 71 | Харааны шил | 15.000 |
| 72 | Контактны линз (+5,-5 болон түүнээс дээш) | 100.000 |
| 73 | Өвдгөвч | 10.000-15.000 |
| 74 | Ярьдаг цаг | 25.000 |
| 75 | Брайль цаг | 30.000 |



| | | |
|----|--|---------|
| 76 | Ярьдаг даралтын аппарат | 150.000 |
| 77 | Ярьдаг халууны шил | 50.000 |
| 78 | Бичиг томруулагч линзэн шил | 30.000 |
| 79 | Радио хүлээн авагч | 50.000 |
| 80 | Компьютерийн ярьдаг программ хангамж, нэмэгдэл төхөөрөмж | 200.000 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 8-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай

Газрын тухай хуулийн 18.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дэвсгэрт 8.0 мянган га газар, Увс аймгийн Ховд сумын нутаг дэвсгэрт 20.9 мянган га газар, нийт 28.9 мянган га газрыг Баруун бүсийн аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч, тус отрын бэлчээр нутгийг “Ачит нуур” гэж нэрлэн хилийн цэсийг хавсралт ёсоор баталсугай.

2. Баруун бүсийн аймаг дундын отрын бүс нутгийг ашиглахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Ц.БАЯРСАЙХАН

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Х.БАТТУЛГА



Засгийн газрын 2012 оны 158 дугаар
тогтоолын хавсралт

БАРУУН БҮСИЙН АЙМАГ ДУНДЫН ОТРЫН
БЭЛЧЭЭРИЙН ХИЛИЙН ЗААГ

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | | Газрын нэр | Тоот өндөр |
|----------------------------------|--------|----|------|---------|----|------|-----------------------------------|------------|
| Баян-Өлгий аймаг Ногоон нуур сум | | | | | | | | |
| 1 | 90 | 17 | 41.0 | 49 | 36 | 9.0 | | 1468 |
| 2 | 90 | 20 | 24.5 | 49 | 37 | 30.7 | | |
| Аймгийн хилийн дагуу | | | | | | | | |
| 3 | 90 | 27 | 41.0 | 49 | 31 | 20.0 | | |
| 4 | 90 | 25 | 40.0 | 49 | 31 | 22.4 | | 1435.4 |
| 5 | 90 | 23 | 33.4 | 49 | 30 | 44.1 | | 1589.5 |
| 6 | 90 | 21 | 24.8 | 49 | 31 | 19.2 | | 1616.3 |
| 7 | 90 | 17 | 33.6 | 49 | 32 | 50.0 | | 1524.2 |
| Увс аймаг Ховд сум | | | | | | | | |
| 1 | 90 | 40 | 39.7 | 49 | 35 | 45.5 | Бөхмөрөн, Ховд сумдын хилийн зааг | 1449 |
| 2 | 90 | 46 | 23.3 | 49 | 33 | 0.3 | Шар толгой | 1509.1 |
| 3 | 90 | 47 | 14.6 | 49 | 31 | 0.6 | Дээд тавиач уул | 1667 |
| 4 | 90 | 45 | 48.8 | 49 | 27 | 19.6 | Элсэн зуух | 1646 |
| 5 | 90 | 45 | 48.8 | 49 | 23 | 29.6 | Гурван шовгор уул | 1789.1 |
| 6 | 90 | 44 | 15.9 | 49 | 21 | 39.3 | Улаан лонх уул | 2094.1 |
| 7 | 90 | 43 | 15.1 | 49 | 20 | 51.7 | Газар балархай | 1741 |
| 8 | 90 | 41 | 27.8 | 49 | 19 | 25.5 | Нарийн хоолын гол | 1437 |
| Аймгийн хилийн дагуу | | | | | | | | |
| 9 | 90 | 40 | 3.7 | 49 | 25 | 33.7 | | |
| Ачит нуурын эрэг дагуу | | | | | | | | |
| 10 | 90 | 39 | 49.9 | 49 | 35 | 13.6 | | |

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turii_medelel@parliament.mn
Утас: 262420, 329612
Хэвлэлийн хуудас: 4.25
Индекс: 14003